



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2016 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/416

Булган

“Засгийн газрын болон аймгийн
Засаг даргын 100 хоног” үйл ажиллагааг зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын 2009 оны 190 дүгээр тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн ХЭГ/1501 тоот албан бичгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 100 хоног”-ийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: - Б.Ууганбаяр - АЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:

- Д.Алтаншагай ТЗУХ-ийн дарга
- Э.Түвшинмөнх - НБХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
- П. Хишигдаваа - ХЭЗХ-ийн дарга
- Д.Буманбаяр - ХОХБТХ-ийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
- О.Наранжаргал - СТСХ-ийн дарга
- Б.Отгонсүвд – НБХ-ийн мэргэжилтэн
- Д.Оюунбилэг –ГБХЗХГ-ын дарга
- Д.Цогоо – БСУГ-ын дарга
- М.Ариунболд- Булган сумын Засаг даргын орлогч
- Д.Наранбаяр - Булган сумын Засаг даргын Тамгын газрын дарга
- Ц.Энхтуяа – Булган сумын Соёлын ордны захирал
- М.Нуваантая – ЭБЦТС ТӨХК-ний захирал

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: О.Ундрах – ТЗУХ-ийн мэргэжилтэн

2. “Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 100 хоног” үйл ажиллагааг 2016 оны 10 дугаар сарын 27-ноос 11 дүгээр сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж батлуулсугай.

3. Үйл ажиллагааг зохион байгуулахдаа Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго чиглэлийг мэдээлэхийн зэрэгцээ олон нийтийн саналыг хүлээн авч газар дээр нь шийдвэрлэж, бодлого шийдвэрт тусган хэрэгжүүлэхэд онцлон анхаарч “Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 100 хоног”-ийн нэгдсэн үйл ажиллагааг бэлтгэл зохион байгуулалт сайтайгаар зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Ууганбаярт/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ